

Б.ШАРАВЫН “ЗАМБУУ ТИВИЙН НАРАН” МАГТУУ БА ТҮҮНИЙ ХӨГЖМИЙН ХЭЛЛЭГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Самбуугийн Энхбулаг

Монгол улсын консерватор, Хөгжмийн ухаан дуулаачийн сургууль,
Улаанбаатар, Монгол улс
mongolkhugjim@gmail.com

Хураангуй: Орчин цагийн монголын хөгжмийн урлагийн нэгэн томоохон төлөөлөгч болох хөгжмийн зохиолч Б.Шаравын “Замбуу тивийн наран” магтуу бол түүний өөрийн гэсэн өвөрмөц хөгжмийн сэтгэлгээний анхны уран бүтээл юм. Энэхүү бүтээлийн хөгжмийн хэллэг нь ая, аялга, хэмнэл, дуурьсал, найрууламж, хэлбэр бүтэц зэрэг олон талаараа монголын хөгжмийн урлагт шинэчлэл болсон байдаг. Таван хэсгээс бүрдэх уг магтууд үндэсний хэв маягийг хадгалахаасаа гадна ХХ зууны хөгжмийн зохиомжийн “modern” арга барилуудыг өргөнөөр ашигласан байгаа нь тус бүтээлийн ач холбогдлыг өндөрт өргөж байх ба улмаар залуу уран бүтээлчдэд тодорхой хэмжээнд үлгэр жишээ, үр нөлөөгөө үзүүлж байгаа билээ.

Түлхүүр үгс: “Замбуу тивийн наран” магтуу, агуулга, хэлбэр бүтэц, үндэсний хэв маяг, орчин үеийн “modern” арга барил

AN ANALYSIS OF B.SHARAV’S “ZAMBUU TIVIIN NARAN” CANTATA AND HIS TONE OF MUSIC

Enkhbulag Sambuu

School of Music and Singing, Mongolian State Conservatory, Ulaanbaatar, Mongolia
mongolkhugjim@gmail.com

Summary: The “Zambuu Tiviin Naran” - “The Sun of the Human Realm” cantata, was the first work that showed the unique way of musical thinking of one of the biggest representatives of Mongolian modern music and art, composer B.Sharav. The musical expression of this piece has been an innovation in Mongolian music because of its melody, tone, rhythm, harmony, arrangement, and structure. The importance of this cantata which consists of 5 parts is held high because of the way it implemented the “Modern” composition methods of the 20th century while still keeping the traditional style. Therefore, it has been an example for young and aspiring artists.

Keywords: “Zambuu Tiviin Naran” cantata, meaning, form, traditional style, the “modern” method

Оршил

Хөгжмийн зохиолч Б.Шаравын гэж болох хөгжмийн хэллэг, арга барилыг түүний хоёрдугаар симфониор төсөөлж, тодорхойлж байдаг бол харин түүний анхны санаа, эхний оролдлого, эрэл, хайгуул, туршилт нь хаана, юунд, ямар байдлаар илрэх болсныг судалж үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хэлбэр бүтцийн хувьд ая аялгуу, хэмнэл, зохирол гэх мэт хөгжмийн хэллэгийн олон талаас нь уг зохиолыг нэг бүрчлэн задлан шинжлэх, эргээд тэдгээрийгээ нэгтгэн, үр дүн, ач холбогдлыг дүгнэх зэрэг арга барилаар ажиллах хэрэгтэй болж байгаа юм.

Хөгжмийн зохиолч Б.Шаравын “Замбуу тивийн наран” магтуу бүтээлийн талаар судалгаа болоод ямар нэгэн эрдэм шинжилгээний өгүүлэл, сонины нийтлэл, зарим нэг сонины мэдээллийг эс тооцвол тэр бүр элбэг тохиолдохгүй байгааг энд дурдах нь зүйтэй юм¹.

1980 онд түүний бичсэн, төгөлдөр хуур, хийл, морин хийлд зориулсан гурвал нь хэдийгээр амжилттай бүтээл болж чадсан боловч Б.Шаравын хувьд өмнөх үеэсээ суралцсан, суралцахын хэрээр шүүмжлэлтэй хандсан, арга барилын хувьд салан тусгаарласан, мөн түүндээ цэг тавьсан зохиол болсон юм. Учир нь тэрээр энэхүү гурвал хөгжмөө С.Гончигсумлаа, Л.Мөрдорж нарын зэрэг ахмад уран бүтээлчдийн “нөмөр, нөөлөг, нөлөөн” дор бичсэн бөгөөд түүнийгээ ч тун удалгүй ухааран мэдэрч, “аялгуу хөөхгүй, агуулга хөөх” тухай бодож эхэлсэн гэдэг. Мөн өрнийн хөгжмийг хойноос нь хөөж уралдах бус өөрийнхөөрөө туурвих нь зүйд нийцэх тухай ойлгож эхэлжээ. Энэ бол нэг талаас хувь уран бүтээлчийн сэтгэлгээ, нөгөө талаас цаг үеэ оновчтойгоор мэдэрсэн хэрэг байлаа. Үр дүнд нь “Замбуу тивийн наран” хэмээх магтуу 1982 онд бий болсон байдаг. Хоёр төгөлдөр хуур, найрал дуу, цохивор хөгжмийн цөөхүүл чуулгад зориулсан “Замбуу тивийн наран” магтуу нь 1985 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Азийн хөгжмийн VII симпозиум-индэр фестивалийн шилдэг бүтээлээр шалгарч, ЮНЕСКО-гийн хөгжмийн алтан санд бүртгэгдсэн юм. Тухайн үедээ “индэрт оролцсон олон орны төлөөлөгчид Б.Шаравын магтууг сонсоод монголын орчин цагийн хөгжмийн хөгжил дэвшлийн ололтыг санал нэгтгэй зөвшөөрөн хүлээцгээж байлаа” (Жанцанноров, 2007, 166).

“Замбуу тивийн наран” магтуу зохиогдсон түүх. “Замбуу тивийн наран” магтуу буюу энэхүү хөгжмийн бүтээл нь хөгжмийн зохиолчийн ярьж байснаар бол “огт санамсаргүй байдлаар, маш хурдан хугацаанд орж ирсэн бүтээл” гэдэг. 1980-д оны эхэн үеийн оюутан Шаравт хэн нэгэн багш зааж, зааварлах ч хугацаа, боломж олдоогүй бөгөөд ердөө л 2-3 хоногийн дотор зохиож дуусгажээ. Шалгалт ч дөхөж байсан, “дотор нь юм орж ирэхгүй дэмий баахан хий эргэсэн” хөгжмийн зохиолч-оюутны дотор гэнэт л энэ хөгжим орж ирсэн хэрэг. Хурдан зохиогоод бичсэн боловч буцаагаад гэж орхих нь ч түргэн зуурын асуудал байжээ. Анд нөхрийнхөө дипломын хамгаалалт руу яарч явах замдаа нийтийн тээврийн унаанд цүнхээ орхин бууснаар шинэхэн бүтээл алга болов. Ингээд дахин ажиллаж сэргээн бичихдээ “сохорсон биш завших”-ын үлгэрээр нэг төгөлдөр хуурт байсан бүтээлээ

¹ Үүнийг бичигч МУКонсерватори, Б.Шарав сангаас зохион байгуулсан “Б.Шарав: Баярлалаа” 70 жилийн ойд зориулсан ЭШХ-д “Б.Шарав. Замбуу тивийн наран магтуу ба бүтээлийн гурвалжин” сэдвээр илтгэл тавьсан /2022.11 сар/.

хоёр төгөлдөр хуурт болгон бичсэн нь түрүүнийхээсээ илүү сайн дуугаралттай болсон аж. Уг зохиолоо үгтэй дуулуулах учиртай байсан боловч хүний газар түүнд шүлэг бичээд өгөх яруу найрагч, эс бөгөөс бэлэн шүлэг зохиол олдоогүй учир дан төгөлдөр хуур дээр эгшиглүүлжээ. Харин зуныхаа амралтаар эх орондоо ирсэн даруйдаа үг, шүлэгний эрэлд гарч, эцэс сүүлд нь уртын дууны сонгомол шүлгээс “зээл” авч гүйцээсэн байдаг. Тухайн зохиолын анхны тоглолт болох шалгалтын үеэр түүний мэргэжлийн багш, олон монгол хөгжмийн зохиолчдод урлах эрдэм заан сургаж байсан, татар үндэстэн Гибалин багш нь түүний зохиолыг өндөр үнэлж, “Энэ чинь л чинийх юм биш үү” хэмээн уулга алдаж байсан аж. Бүтээл төрсөн түүх ийм бөлгөө.

“Замбуу тивийн наран” магтууны агуулга, гүн ухаан. “Замбуу тивийн наран” магтуу бол нарны тухай магтаал дуу юм. Хүн төрөлхтний хөгжлийн аль ч цаг үед нарыг магтан дуулах түгээмэл хэрнээ сонгодог агуулга байсан аж. Тэр тусмаа эртний түүх, уламжлалт ёс заншил бүхий нүүдэлчин монголчуудын хувьд нар, сарыг магтан дуулах нь амьдралын зайлшгүй нэгэн хэв маяг, нэг хэсэг нь байв. Нарыг магтсан үлгэр, домог, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, оньсого таавар байдаг бол дуу хуурандаа нарыг магтан дуулсан нь цөөнгүй бий.

“Дуртмал сайхан нарныхаа өнгөтэй

Тунамал өгүүлшгүй сүлд тэмдэг маань” (уртын дуу “Дуртмал сайхан”)

“Дуртмал хурцхан чиг нарны гэрлээр

Тогтож ядан ганхана” (уртын дуу “Тунгалаг Тамир”)

“Сар нар шиг дэлгэрээд

Сайн үйлсийг бүтээгээд” (уртын дуу “Эрхэм төр”) гэх мэтээр дуулсан байдаг

бол “Уяхан замбуу тивийн нар” дуунд:

“Үүлэн чөлөөний нар мэт

Өчүүхэн явах насаа

Үнэн мөнх дор бодож

Үгүй муухайгаар хууртдаг шүү” хэмээжээ.

Нарны баримжаагаар мал ахуйгаа зохицуулж, нараар хөтөчлөн өдөр хоногийг тоолон амьдарч, өвөл зуны дөрвөн улирлын дараалалд оршин амьдарч байдаг нүүдэлчин монголчуудад хөх тэнгэртээ мөнхөд бадрах нар гэдэг бол амь, амьдралын хамгийн чухал эх үүсвэр байдаг юм. Аливаа сайн сайхан бүхнийг нартайгаа, тэнгэртэй холбон шүлэглэж хэлэх, өгүүлэх, дуулах нь монголчуудын уран сайхны сэтгэлгээ, цаашилбал хөгжмөн ертөнцийн нэгэн онцлог болох юм.

Хөгжмийн зохиолч Б.Шарав “Замбуу тивийн наран” магтуудаа тэрхүү “нар”-ыг магтан дуулахын зэрэгцээ түүнийг дагасан хүний амьдралын ухааныг ёс суртахуунтай, зөв зүйтэй байлгахын учир утгыг мөн хөгжмөөр илэрхийлэн дуулсан аж. “Замбуу тивийн наран” магтууны агуулгын тухай ба үг, шүлгийн сонголт. Хөгжмийн урлагт үгийн урлагтай, шүлэг, яруу найрагтай холбоотойгоор нэгдүгээрт, шүлэгт ая оруулах, хоёрдугаарт, аялгуунд үг тааруулах гэсэн хоёр зам байдаг. Хөгжмийн зохиолч Б.Шарав энэхүү магтуу болон хоёрдугаар симфонидоо хоёр дахь замыг сонгон ажилласныг бүтээлүүдийн түүхээс мэдэж авч болох юм. “Замбуу тивийн наран” хэмээх магтууд хөгжмийн зохиолч нь үгийн сонголт хийхдээ хэд хэдэн уртын болоод ардын богино дууны үгээс авч ашигласан гэдгийг

доорх жишээ, харьцуулалтаас харж болно. Б.Шаравын өөрийнх нь ярьж байснаас үзвэл, тэрээр шүлэг, яруу найрагт ихээхэн шүүлтүүртэй ханддаг байсан байх ба түүний нэг тод илрэл нь энэхүү магтууд хийсэн үгийн сонголт болж таарна. Тэрээр яруу найрагчдын хэвлүүлсэн шүлгийн эмхэтгэл, товхимлуудыг шүүрдэн үзэхийн зэрэгцээ уран бүтээлийн найз нөхдийн хүрээнд шүлэг захиалах зэргээр яруу найрагт хандаж байсан боловч том хэлбэрийн бүтээлүүдийнхээ шүлгийг уртын дуунуудаас сонгон авч дуулуулжээ. Энэ бол түүний уран бүтээлч сэтгэлгээ, үгийн урлагт хандах өндөр шүүлтүүр байж болох юм. Түүний шүүлтүүр нь зөвхөн үгийн хэллэг, түүний хэмнэл төдий бус агуулгын цар хүрээ, хэм хэмжээ, гүн ухааны утга санаанд оршиж байсан гэж үзэж болохоор байна.

Б.Шаравын “Замбуу тивийн наран” магтууд монгол уртын дуу “Уяхан замбуу тивийн наран”, “Эрхэм төр”, “Түмний эх”² болон “Хайлуур мөрөн”, “Сийлэн бөөр”³ зэрэг ардын дууны шүлгүүдээс авч ашиглажээ.

Хөгжмийн зохиолч Б.Шаравын “Замбуу тивийн наран” магтууд ашигласан болоод дуулагдаж байгаа үгийг түүвэрлэж бичиж үзвэл дараах байдал харагдана.

Хүснэгт 1. Шүлгийн сонголтыг хийсэн байдал

	Б.Шарав “Замбуу тивийн наран” магтуу	Ямар дууны үг болох тухай	Зохиолын аль хэсэг
Нарны магтаал	Мандаж гардаг нарны наагуур Манан ч үгүй тунгалаг байнаа	Монгол ардын дуу “Сийлэн бөөр”	Нэгдүгээр хэсэг Andante / эхлэл хэсэг
	Шил дээр унасан цасыг хө Ширгэтэл хайлуулдаг нараа хө	Монгол ардын дуу “Хайлуур мөрөн” дууны хоёр бадгаас	Хоёрдугаар хэсэг Allegro / цифр 4
	Ууланд унасан цасыг хө Урстал хайлуулдаг нараа хө		Цифр 5
	Шил дээр унасан цасыг хө Ширгэтэл хайлуулдаг нараа хө		Цифр 8
Амьдралын гүн ухаан	Үүлэн чөлөөний нар шиг Өчүүхэн явах энэ насаа Үнэн мөнх дор барьж Үгүй муухайгаар хууртдаг шүү дээ	“Уяхан замбуу тивийн наран” уртын дуу	Гуравдугаар хэсэг Adagio / цифр 11-12
	Жаа. Энэ сайхан замбуу тивийн нар Илхэн бүхий дэлхий дээгүүр Мөхдөл үгүй түгэн дэлгэрч Мандаж мандсаар байдаг билүү зээ За тэр лугаа нэгэн адил Олон түмний минь ач өршөөл Үнэн сэтгэлтэй бүхнийгээ зээ Ялгалгүй асарсаар байдаг билүү		Дөрөвдүгээр хэсэг Цифр 14

¹ Уртын дуунуудын үгийг Ж.Дорждагвын 1970 онд гаргасан эмхэтгэлээс (“цэнхэр”) авав.

² Ардын дуунуудын үгийг дуучин Алтанжаргалын дуулснаар youtube-ээс бичиж авсан болно.

Сайн сайхны магтаал	<p>Эрдэнэт хүний биеийг олж Этгээд буруу зүйлээс зайлж Эцэс эдүгээгийн хоёр хэргийг Бүтээхэд бүрэн сэдэлтэй зээ Сайн үйлсийн тулд Амин зүрхнээсээ Сайхан төрийн тулд Ахуй чинээгээрээ Сайгар шамдан зүтгэлтэй зээ</p>	Уртын дуу “Түмний эх”	Цифр 17
	Энэ сайхан замбуу тивийн нар	“Уяхан замбуу тивийн наран” уртын дуу	Цифр 20
	<p>Эрхэм төр энхжээд Эрх чөлөө нь тунгалаг Энгийн олон нөхөдтэйгөө Эгүүрд хамтаар цэнгэн жаргацгаая</p>	Уртын дуу “Эрхэм төр”	Тавдугаар хэсэг Maestoso / цифр 25
	<p>Сар нар шиг дэлгэрээд Сайн үйлсийг бүтээгээд Сайгар шамдан хичээцгээж Сайхан тааваар жаргацгаая</p>		Цифр 26

Дээрх хүснэгтийг ажиглахад Б.Шарав ардын дууг сонгохдоо нэлээд болгоомжтой хандсан нь анзаарагдах бөгөөд ялангуяа тэдгээр дуунуудын үгийг таслан авч хэрэглэхдээ магтууныхаа агуулгад онцгой анхаарал хандуулсан байгаа нь харагдаж байна. Ийм байдлаар хөгжмийн зохиолч нь хөгжмөө бэлэн болгосноос хойш (мэргэжлийн шалгалтанд тоглохдоо үггүй байсан гэдгийг энд дахин тэмдэглэв) үг, шүлгийг сонгон бүрдүүлснээр нэг ёсондоо бол зохиолын цомнолыг бий болгосон хэрэг юм. Өөрөөр хэлбэл, тухайн дуунуудаас ахуйн чанартай, амин хувийн хайр сэтгэл зэрэг зүйлтэй холбогдол бүхий хэсгүүдийг орхисон байх ба түүнээсээ илүүтэй гүн ухааны агуулга, утга санаа бүхий мөрүүдийг таслан авч сонгосон байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь, “Сийлэн бөөр” дууны зөвхөн гуравдугаар бадгийг сонгож авахдаа тэндээс эхний 2 мөрийг тасдан авчээ. Энэ нь нарыг магтан дуулсан хэсэг байдаг юм.

“Мандаж гарах нарны наагуур

Манан ч үгүй тунгалаг байна хө” гэсэн нарны дууллыг нь аваад “Манай айлын Сийлэн бөөрийг Маргааш өглөө мордуулна гэнэ дээ хө” гэсэн аж амьдрал, ахуйн холбогдолтой хэсгийг нь орхисон аж. Эндээс үзвэл, хэдийгээр “Сийлэн бөөр” дуу нь янаг амрагийн явдлыг өгүүлэх боловч уг дууны нарыг магтан дуулах, нар нь хэдий гэрэл түгээх боловч манан ч үгүй байтугай тунгалаг байгаа тухай өгүүлсэн хэсгийг Б.Шарав магтууныхаа эхний хэсэгт оруулж өгсөн байна.

Дараагийн хэсэгт “Хайлуур мөрөн” дууны гурав ба дөрөвдүгээр бадгийг сонгон авахдаа гуравдугаар бадгийн эхний

“Шилэн дээр унасан цасыг хө

Ширгэтэл хайлуулдаг нь нар юм аа хө” гэсэн эхний хоёр мөр, дөрөвдүгээр бадгийн

“Ууланд унасан цасыг хө

Уртал хайлуулдаг нь нар юм аа хө”

гэсэн зөвхөн нарны тухай хэсгүүдийг таслан авсан бөгөөд хувь хүний хайр сэтгэлийн агуулгатай хэсгийг орхиж үлдээсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл, зохиолын, “цомнол”-ын эхний хэсэгтээ, сонгосон ардын дуунуудаасаа нарыг магтан дуулсан хэсгүүдийг багцлан авч, огторгуйн нарны тухай гүн ухааны өгүүлэмжийг бий болгож, түүгээрээ нарыг магтан дуулжээ.

Харин дараагийн хэсэгт “Уяхан замбуу тивийн наран” хэмээх уртын дууны үгнээс татан авсан байна. Хэрвээ алдарт уртын дууч Ж.Дорждагвын түүвэрт (Дорждагва, 1970, 23) уг дууны 4 бадаг байна гэж үзвэл, тэдгээрээс эхний 3 бадгийг сонгон авсан байх ба тэдгээрийг энэхүү магтуунд хэрэглэхдээ эхлээд 3-р бадгийг, дараа нь 1-р бадгийг оруулсан бөгөөд түүний дараагаар 2-р бадгийг авч хэрэглэжээ (*Хүснэгт 1*). Ийнхүү уртын дууны бадгуудын цувааг өөрчилснөөр хөгжмийн зохиолч Б.Шарав өөрийн гэсэн амьдралын гүн ухааныг дараах байдлаар буюу амьдрал гэдэг өөрөө мөнх бус, замбуу тивийн наран бол мөнх юм, харин үнэнч, зөв сэтгэлийг олноороо нигүүлсэн өршөөдөг хорвоогийн тухай үзэл бодлоо илэрхийлсэн байна.

“Уяхан замбуу тивийн наран” дууны бадгийг үргэлжлүүлэн “Түмний эх” дууны шүлэг орж ирэх ба хэрвээ энэ дууг 6 бадаг дуу гэж үзвэл түүний эхний хоёр бадгийг энэхүү магтуунд ашиглажээ. Дашрамд дурдахад, уг дууны ахуйн буюу тодорхой өгөгдөл бүхий хурдан морины тухай агуулгатай 3, 4-р бадгийг хөгжмийн зохиолч Б.Шарав огт хөндөлгүй орхисон бөгөөд харин дараагийн 5, 6-р бадгийг өөрийнхөө хоёрдугаар симфонийнхоо төгсгөлийн найрал дуунд ашигласан байдаг.

“Түмний эх” дууны эхний хоёр бадагт хүний амьдралын одоо ба ирээдүйн тулд сайн сайхан зүйлс бүтээхийг уриалан сануулсан байдаг бол “Эрхэм төр” дуунаас тодорхой агуулгад үл баригдсан амар тайван амьдралын тухай бадгуудыг магтууныхаа төгсгөлд дуулуулжээ.

Энэ бүхнээс үзвэл, хөгжмийн зохиолч Б.Шарав өөрийн зохиосон “анхдагч” томоохон хэлбэрийн хөгжмийн бүтээлдээ уртын болон ардын дууны шүлгээс бүрдсэн шинэ цомнолыг бий болгосон нь онцгой үзэгдэл болохын хэрээр орчин цагийн монголын хөгжмийн түүхэнд чухал ач холбогдолтой шинэлэг шийдэл болсон юм. Гэхдээ дууны агуулгыг илэрхийлж буй шүлгийн өгүүлэмж дэх ахуй амьдрал, янаг амраг, адуу малын тухай хэсгүүдийг авахгүйгээр орхисон байгааг анхаарвал зохистой. Өөрөөр хэлбэл, хөгжмийн зохиолч Б.Шарав нь монголчуудын ертөнцийг үзэх үзлийг, нүүдэлчдийн, амьдралын ухааныг (гүн ухааныг) тодорхой хэмжээнд илэрхийлэн гаргасан уртын дууны болон ардын богино дууны шүлгэн цомнолоор дамжуулан өөрийнхөө, хувь уран бүтээлчийн гүн ухааны үзэл санааг үндсэн гурван бүлэгт хувааж (нарны тухай, амьдралын гүн ухаан, сайн сайхны магтаал), тодотгон гаргаж өгчээ гэж үзэж байна.

“Замбуу тивийн наран” магтууны хөгжмийн хэллэг. “Замбуу тивийн наран” магтуу нь хөгжмийн хэллэгийн хувьд “Уяхан замбуу тивийн наран” хэмээх уртын дуутай аялгууны болоод хэм хэмнэл зэрэг бусад ямар нэг талаар холбогдолгүй юм. Өөрөөр хэлбэл, хөгжмийн зохиолч Б.Шарав энэхүү зохиолдоо ижил нэртэй уртын дууны аялгуунаас ашиглаагүй бөгөөд түүний “Уяхан замбуу тивийн наран”,

“Замбуу тивийн нар” гэдэг нэрийг “Замбуу тивийн наран” хэмээн өөрчлөн авчээ. Харин түүний дараа дараагийн уран бүтээлүүдэд дуурьсах “ШАРАВЫН” гэж болох нийтлэг аялга, аялгын хэв маяг болох санаа энд байгааг тус бүтээлээс эхлэлтэй гэдгийг дурдах нь зүйтэй.

“Замбуу тивийн наран” магтуу нь хөгжмийн хэлбэр бүтцийн хувьд өрнийн сонгодог хөгжмийн уламжлалаас ангид орших бөгөөд үүгээрээ хөгжмийн зохиолч Б.Шарав цаашдын уран бүтээлийнхээ хэв маяг, ерөнхий загварыг бий болгосон хэмээн үзэж болохоор байгаа юм. Учир нь түүний дараа дараачийн бүтээлүүд нь ямар нэгэн байдлаар хэлбэр бүтцийн энэхүү зарчмыг үргэлжлүүлэн хадгалсан байдаг нь анзаарагдаж байдаг. Энд түүний нэг ба хоёрдугаар симфониудыг онцгойлон тэмдэглэж байна. Тэмдэглэхийн учир нь “Замбуу тивийн наран” магтуу болон нэгдүгээр симфони, хоёрдугаар симфониуд нь үзэл санаа, агуулга, хөгжмийн хэллэг, хэлбэр бүтэц зэрэг олон талаараа ойролцоо бөгөөд хөгжмийн зохиолч Б.Шаравын гурвалсан (“трилог”) бүтээлүүд хэмээн тодорхойлж болохоор байна.

“Замбуу тивийн наран” магтууны хөгжим нь хэдийгээр нэг ангитай боловч дотроо үндсэн 5 хэсгээс бүрдэж байдаг. Тэдгээрийг агуулгын талаас нь багцлан үзвэл, “нарны магтаал”, “амьдралын гүн ухаан”, “сайн сайхны магтаал” гэсэн гурван үндсэн хэсэг байж болохоор харагдаж байна.

Хүснэгт 2. “Замбуу тивийн наран” магтуу, түүний хэлбэр бүтэц

I	II	III	IV	V	Coda
Andante	Allegro	Adagio	Allegro	Allentato	Maestoso
	Цифр 4	Цифр 11	Цифр 14	Цифр 23	Цифр 25
Мандаж гардаг нарны наагуур	Шил дээр унасан цасыг хө	Үүлэн чөлөөний нар шиг	Жаа. Энэ сайхан замбуу тивийн нар		Эрхэм төр энхжээд
Нарны магтаал		Амьдралын гүн ухаан		Сайн сайхны магтаал	

Агуулгын талаасаа хуваагдсан дээрх 3 хэсэг нь үндсэндээ хөгжмийн хэлбэрийн 5 хэсэгтэй учир зүйн утгаараа холбогдож байгааг энд тэмдэглэх нь зүйтэй.

Цаашилбал, дээрх үндсэн 5 хэсгийг хэсэг тус бүрээр нь задлах аваас дараах хэлбэрийг олж харах болно. Үүнд:

Хүснэгт 3. Хэсэг тус бүрийн задаргаа

I	II	III	IV	V	Coda
Andante	Allegro	Adagio	Allegro	Allentato	Maestoso
$a+b+a_1$	$a+a_1+a_2$	$a+b+a_1$	$a+b+a_1$	A	B
Тактгүй+такт+үгүй	$A+b+b_1+c/a+b_2+c/a+c$	$b=var.$			
	$6+8+9+9+6+8+9+12+4$				

Хөгжмийн зохиолч Б.Шаравын энэхүү бүтээл нь тодорхой дэвсгэр хөгт үл захирагдах ба энд долоон эгшигт болон таванэгшигт хөгүүд дээр суурилсан байхаас гадна тодорхой хөгийг үгүйсгэсэн “atonal” хөгжмийн зарчмыг баримталсан байдаг. Гэхдээ дийлэнхдээ таванэгшигт хөгийг орчин үеийн (modern) буюу XX зууны сүүлийн хагаст өрнийн хөгжмийн ертөнцөд түгээмэл хэрэглэгдэж байсан

нэгэн шинэ арга барил болох алеаторик⁴-ийг хэрэглэсэн байгаа нь сонирхолтой дуугаралт, хөгжмийн өвөрмөц хэллэгийг бий болгосон байх ажээ.

Дээр дурдаж байсанчлан, хөгжмийн зохиолч Б.Шаравын трилог буюу гурамсан бүтээлүүд хэмээн нэрлэхийн нэг учир нь уртын дууны ая, аялгын холбоост байгаа юм. Гэтэл энэхүү магтууд уртын дууны үг, шүлгээс авч хэрэглэсэн байхаас ая, аялгын хувьд шууд холбоос байхгүй гэж болно. Өөрөөр хэлбэл, уртын дууны аялгуунаас авсангүй. Харин дээр дурдаж байсан хэд хэдэн уртын дууны шүлгээс хэсэгчлэн авчээ.

Уг зохиолын Andante – I хэсэгт таванэгшигт G хөгийн III хувилбарт суурилсан аялгууг 6 удаа дараалан дуулуулахдаа таванэгшигт G хөгийн гуравдугаар хувилбарыг буюу дээрх аялгууг үндсэндээ хэвээр нь үлдээгээд хэмнэлийн хувьд байж болох хувилбаруудаар өөрчлөн давтсан байгаа нь анхаарал татаж байна. Энэ тохиолдолд аялгууны болоод хэмнэлийн өөрчлөлт нь хөгжмийн зохиолчийн уран сэтгэмжийг илэрхийлэхээс гадна түүгээр дамжуулан аливаад үл захирагдах, чөлөөт орон зайн мэдрэмж зэрэг сэтгэлгээний эрх чөлөөг тодорхойлж байгаа юм. Дээр дурдагдаж буй аялгуу бол уртын дууг санагдуулсан, аялгууны эрх чөлөөг мэдрүүлсэн 4-5 эгшгийн “тоглолт” юм.

“Замбуу тивийн наран” магтууны эхний аяыг 6 удаа давтсан буюу “Мандаж гардаг нарны наагуур манан ч үгүй тунгалаг байнаа” хэмээх үгийг ийнхүү 6 удаа аялгуулан дуулсан байдаг.



Зураг 1. Ноотны жишээ

Эндээс үзвэл g-a-c-d-f гэсэн таванэгшигт эхний (№1) аялгууг хэд хэдэн сонирхолтой хувилбараар өөрчлөн хэрэглэсэн байгаа нь хөгжмийн зохиолчийн уран сэтгэмжийг илэрхийлэх нэг жишээ гэж болно. Хэдийгээр аялгууны үндсэн хөдөлгөөнийг хадгалсан мэт боловч хэмнэлийн тодорхойгүй буюу бие биенээсээ үүссэн хэмнэлийн өөрчлөлтүүд нь сонсогчдод нэг бодлын ижил аялгуу мэт

⁴ Алеатори гэдэг нь (англи. *Aleatory-toхиолдлын*, латин. *aleatorius* - тоглоом) XX-XXI зууны хөгжмийн зохиомжийн арга барил ба хөгжмийн ая аялгууны зохион байгуулалтанд үүсэх тохиолдлын харьцааг илэрхийлж байдаг. Эндээс үүдээд хөгжмийн хэлбэр бүтцийн хувьд ч мөн тохиолдлын өөрчлөлтүүд бий болж байдаг.

санагдах авч нөгөө бодлын аялгууныхаа хэмнэлийн өөрчлөлтөөр ялгарамжийг бий болгож байгаа, маш нарийн мэдрэмж, ур ухаан шалгасан нэн сонирхолтой шинэлэг зохиомжийн арга гэж харагдаж байгаа юм.

Дуучны араас хоёр төгөлдөр хуурт дээрх аялгууг 5 удаа давтах ба энэ нь өмнөх болоод дуучдын дараах хэсгээс өөрийн өвөрмөц дуурьслаар тодорхой ялгарамжийг бий болгож байдаг. Бүтцийн талаас нь авч үзвэл, а+в+а гэсэн 3 ангит хэсгийн төгсгөлд орчин үеийн зохиомжийн дуурьслын аргаар найрал дуучид төгсгөнө. Энэ тохиолдолд уг хэсгийн эхний аялгууг сопрано, альт, тенор, басс хоолойнууд наймтын паузын завсартайгаар ээлж дараалан нэмэгдүүлэн мөшгөж дуулж байгаа нь сонорик (sonorus) арга барилын тод жишээ болж харагдахаар байна.

Хүснэгт 4. Мөшгөл буюу sonorus

Сопрано I						ая	
Сопрано II				ая			
Альт I			ая				
Альт II		Ая					
Тенор I	Ая						
Тенор II			ая				
Басс I					ая		
Басс II							Ая

“Замбуу тивийн наран” магтууны дээр дурдсан нэгдүгээр хэсэг нь гоцлол дуучин болоод төгөлдөр хуурчийн гэж болох 2 хэсгээс бүрдэх бөгөөд найрал дуучид, 2 төгөлдөр хуур, цохивор хөгжимчдийн хамтарсан “tutti” төгсгөлтэй байгаа нь үндсэндээ зохиолын таниулах хэсгийн давталтын үүргийг гүйцэтгэж байгаа юм.

Хүснэгт 5. 1-р хэсгийн бүтцийн задаргаа

I хэсэг / andante		
А	В	А
Гоцлол дуучин/ тенор	Төгөлдөр хуур	Найрал дуучид, 2 төгөлдөр хуур, цохивор хөгжимчдийн хамтарсан “tutti”
Andante		
Цифр 0-1	Цифр 2	Цифр 3

Төгөлдөр хуур, цохивор бүхий хоёрдугаар хэсэгт (Allegro - дуулаачгүй) аялгууны бүтээмж нь үндсэндээ нэгдүгээр хэсгийн зохиомжийг давтах мэт хийцтэй байх аж. Хэрвээ нэгдүгээр хэсгийн аялгуу нь таванэгшигт хөгийн 3-4 эгшгээс бүрдсэн байсан энд мөн тэр хэмжээний эгшгийн “тоглолт” байна. Дашрамд дурдахад, таванэгшигт хөгийн чухам аль хувилбарт байгааг тодорхойлоход төвөгтэй. Төвөгтэй байхын бас нэг шалтгаан нь төгөлдөр хуурын зүүн гарт дуурьсах контрапунктийн аялгуу болно. Тэрээр контрапунктийн үүрэг гүйцэтгэхдээ давхар “политональ” харьцаа бүхий дуурьслыг бий болгож байдаг.



Зураг 2. Ноотны жишиг: Цифр 4

Энэхүү төгөлдөр хуурын аялгуу бол зохиолын эхний аялгууны (тенор дуучны) бас нэгэн хувилбар гэдэг нь сонсоход мэдрэгдэнэ. Ингэснээр энэ хэсэг бол эхний нэгдүгээр хэсгийн шинэ хувилбарт үргэлжлэл гэж ойлгож болохоор байна. Гэтэл энэ аялгуу нь цаашид хувиран өөрчлөгдөж, дараагийн шинэ аялгууг бий болгожээ. Энэ бол дээрхийн бас нэгэн хувилбарт аялгуу мөн.



Зураг 3. Ноотны жишиг: Аялгууны хувилбар

Хүснэгт 6. 2-р хэсгийн бүтцийн задаргаа

II хэсэг / allegro									
A				A ₁			A ₂		
A	B	B ₁	C	A	B ₂	C	A	A ₁	C
6 такт	8 такт	9 такт	9 такт	6 такт	8 такт	9 такт	4 такт	8 такт	4 такт
Цифр 4		Цифр 5	Цифр 6	Цифр 7	Цифр 8	Цифр 9	Цифр 10		
т/хуур	дуучид	дуучид	дуучид	т/хуур	дуучид	дуучид	т/хуур	т/хуур	дуучид

Дээрх хүснэгтээс үзвэл, энэхүү магтууны II хэсэг нь өөрийн гэсэн зохиомжийн өвөрмөц бүтэцтэй юм. Энэ нь гурван дэд хэсэгтэй ба хэсэг тус бүр нь жижиг мөчлөгүүдээс бүрдэнэ. Тэрхүү мөчлөгүүд нь төгөлдөр хуурчид болон дуучдын харилцан тоглолт дээр суурилж байдаг.

Хүснэгт 7. 2-р хэсэг ба түүнд зориулсан үгийн сонголт

Шил дээр унасан цасыг хө Ширгэтэл хайлуулдаг нараа хө	Монгол ардын дуу “Хайлуур мөрөн” дууны хоёр бадгаас	Хоёрдугаар хэсэг Allegro / цифр 4
Ууланд унасан цасыг хө Урстай хайлуулдаг нараа хө		Цифр 5
Шил дээр унасан цасыг хө Ширгэтэл хайлуулдаг нараа хө		Цифр 8

“Замбуу тивийн наран” магтууны III хэсэг (adagio) аялгууны хувьд анхны аялгууны шинжийг хадгалах хэдий боловч таванэгшигт тогтолцооноос хальж додекафоны⁵ шинж байдлыг түлхүү баримталсан байгаа нь нэлээд сонирхолтой


⁵ Додекафон (грек. δώδεκα - арванхоёр ба грек. Φωνή - эгшиг,өнгө) – хамаарал бүхий 12 эгшгийн

болж чаджээ. Энэхүү хэсгийн эхний 1, 3 ба 5-р тактанд вибрафон хөгжмөөр додекафон дуурьсал эгшиглэх бол дуучдад өгөгдсөн аялгуу нь хэдийгээр таванэгшигт хөгтэй боловч мөн додекафон шинжийг хадгалсан байна.



Зураг 4. Ноотны жишээ: 11-р цифрийн вибрафон тоглолт

Эдгээр 3 аялгуу тус бүрт нь давтсан болоод давхардсан эгшиг байхгүй гэдэг нь дээр дурдсан додекафоны илэрхийлэл мөн аж. Одоо энэ хэсгийн дуучдад зориулсан аялгууг үзье.



Зураг 5. Ноотны жишээ: Аялгууны хөдөлгөөн


Эдгээр 3 аялгуу нь хагас өнгөнөөс зайлсхийн “зугтаасан” таванэгшигт хөг дээр суурилсан хэрнээ додекафоны шинжийг агуулсан байгаа нь харагдана. Өөрөөр хэлбэл, сонсоход хагас өнгө оруулаагүй таванэгшигтийн аялгуу мэт боловч үнэн чанартаа далдлагдсан хроматизм буюу додекафоны шууд арга барилыг авч хэрэгжүүлсэн байна.

Хөгжмийн зохиолч Б.Шарав “Замбуу тивийн наран” магтуундаа орчин үеийн зохиомжийн олон төрлийн сонирхолтой аргуудыг ашигласан байгаагийн нэгэн жишээ нь “тонгоруу”⁶ дуурьсал юм. Жишээ болгон дурдахад, энэхүү 3-р хэсгийн 2 дахь аялгууг эхний аялгууны “тонгоруу” хувилбараар зохиомжилсон байгаа нь өвөрмөц шинэ дуурьслыг бий болгожээ.



цувааг ашигладаг хөгжмийн зохиомжийн арга (герм. “Komposition mit zwölf nur aufeinander bezogenen Tönen”). 1920-д оны эхэн үед австрийн хөгжмийн зохиолч Арнольд Шёнберг санаачлан бий болгожээ.

⁶ Тонгоруу дуурьсал (ракоход) лат. sanctizans, герм. Krebsgang. Аялгууг араас урагш нь унших зохиомжийн арга



Зураг 8. Ноотны жишээ: Энэхүү тонгоруу хувилбарыг алыт хоолойд зориулан 2-р аялгуу болгосон нь

“Замбуу тивийн наран” магтууг эхлүүлсэн тенор хоолойн тэр аялгуу нь энэ хүрэхдээ хөг, аялга, хэм хэмнэл талаасаа олон янз болон хувирсаар додекафоны шинжийг өөртөө агуулан өөрчлөгджээ.

“Замбуу тивийн наран” магтууны үндсэн агуулгыг IV хэсэгт илэрхийлж байдаг.

“Зээ. Энэ сайхан замбуу тивийн нар

Илхэн бүхий дэлхий дээгүүр

Мөхдөл үгүй түгэн дэлгэрч

Мандаж мандсаар байдаг билүү зээ”. Өмнөх хэсгүүдийн нэгэн адил IV хэсгийн аялгуу нь зохиолын анхны санааг үргэлжлүүлэн хөгжүүлсэн байх ажээ.

Хүснэгт 8.4-р хэсгийн бүтцийн задаргаа

IV хэсэг							
Allegro							
A	B				a ₁		
E	E	g	B	Cis	e	B	E
Энэ сайхан замбуутив	Энэ сайхан замбуутив	За тэр лугаа нэгэн адил	Эрдэнэт хүний биеийг олж	Сайн үйлсийн тулд амин зүрхнээсээ	Энэ сайхан замбуутив	Энэ сайхан замбуутив	Энэ сайхан замбуутив

Төгсгөлийн V хэсэг нь 2 бүтэцтэй бөгөөд түүний эхний аялгуу нь хөг, дуурьслын хувьд дээр дурдагдаж байсан додекафоныг санагдуулах ба энэ нь тодорхой хөг, уг зохиолын өмнөх хэсгүүдэд илэрхийлээд байсан аливаад үл захирагдах гэсэн, эрх чөлөөг хүсэмжилсэн санаа байж болохоор байна. Сонсогдох байдлаараа таванэгшигт аялгуу байх боловч үнэн чанартаа зохиомжийн хувьд хроматизм, додекафоны дуурьслыг ашигласан байгаа нь хөгжмийн зохиолчийн уран сэтгэмжийн ил тод илэрхийлэл мөн юм.



Зураг 9. Ноотны жишээ: додекафоны дуурьсал

Харин **Maestoso** хэсэгт найрал дуучид өмнө хэсэгт дуулагдаж байсан аялгууны нэгэн хувилбараар:

Сар нар шиг дэлгэрээд

Сайн үйлсийг бүтээгээд


Сайтар шамдан хичээцгээж

Сайхан тааваар жаргацгаая хэмээн сүрлэг өнгөөр дуулж төгсөнө.

Эндээс харахад уг магтуу нь нэгэн бүлэг зохиол бөгөөд дотроо 5 хэсгээс бүрдэж байна. Хэсэг тус бүртээ хамгийн энгийн хэлбэр бүтцийг сонгосон байгаа

нь сонсогчдод ойлгоход хялбар, хөгжмийг мэдрэхэд хөнгөн дөхүү байх гэсэн хэрэг юм. Ая, аялгууны талаас нь үзвэл, хэдийгээр уртын дууны аялгууг авч хэрэглээгүй боловч уртын дууг санагдуулахуйц 4-5 эгшгүүдээс бүрдсэн цогц дуурьслыг бий болгож чаджээ. Мөн аялгууныхаа зохиомжийн сэтгэлгээнд хэм хэмнэлийн өөрчлөлт, тонгоруу тоглолт, ХХ зууны өрнө дахинд түгэн тархаж, өргөн хэрэглэгдэх болсон додекафоныг энэхүү зохиолдоо багагүй хэмжээнд ашигласан нь сонирхолтой болжээ.

Хэмнэлийн өвөрмөц тогтолцоог зөвхөн аялгуу төдийгүй бусад бүрэлдэхүүний дуугаралтаас харж болно. Дээр дурдаж байсан эхлэл хэсгийн тенор хоолойд зориулсан аялгууны хэмнэлийн өөрчлөлтийг эргэж саная. Мөн гуравдугаар цифрт байх хоолойнуудын хэмнэлийг эвдсэн нь сонорус шинж байдлыг бий болгоно. Мөн дөрөвдүгээр хэсгийн цифр 15-аас эхлэн дуучдад өгсөн оноолтын хэм, хэмнэлийн өвөрмөц өөрчлөлт, тэдгээр нь үгийн дуудлага, хуваарилалттай хэрхэн харьцаж байгаа нь нэгэн шинэ дуурьслыг санагдуулж байдаг. Нөгөө талаас урт, богино догол хэмнэлүүдийг бий болгох замаар улам бүр хүчтэй дуурьслыг гаргаж өгөх ажээ.



Зураг 10. Ноотны жшиээ

Аливаа хөгжмийн бүтээлд олон хоолойн зохиомж, найруулга нь өрнүүлгийн чухал үүрэгтэй байдаг. Хөгжмийн зохиолч Б.Шаравын “Замбуу тивийн наран” магтууг олон хоолойн бичвэргүйгээр төсөөлөх аргагүй юм. Олон хоолойн шинж байдлууд нь уг зохиолыг нэлээд өнгөлөг, баялаг, өргөн дуурьсалтай болгож өгчээ. Олон хоолойн бичлэгийн үндсэн зарчим болох контрапункт, имитац (мөшгөл)-ийг цөөнгүй удаа хэрэглэсэн байгааг энд дурдах болно. Энэ бол нэгдүгээр цифр болон гуравдугаар цифрийн дуурьсал байх бол ялангуяа дөрөвдүгээр цифрт (allegro) төгөлдөр хуурын оноолтын баруун, зүүн гарын контрапункт дуурьслыг онцолж болох юм.



Зураг 11. Ноотны жшиээ


Энэ нь хэдийгээр аялгууны хувьд контрапунктийн зарчмыг харуулж байгаа боловч нөгөө талаар политоналийн шинж байдлыг илэрхийлж байгаа хэрэг юм. Энэхүү политоналийн дуурьсал нь уг зохиолд цөөнгүй удаа хэрэглэгдэж байх ба өөрөө өрнүүлгийн ач холбогдолтой, дуурьслын баялаг өнгө төрхийг бий болгох үүрэгтэй байдаг.

Мөн наймдугаар цифрийн 4 хоолойн хос хоолойгоор дуулах имитац бүхий канон нь зохиолын өрнөлийг эрчимжүүлэхэд чухал үүрэгтэй байх ажээ.




Зураг 12. Ноотны жишээ: имитац буюу мөшгөл

Нэгэнт тодорхой дэвсгэр хөгт үл захирагдаад эхлэхээр гармонийн дуурьслын хувьд өвөрмөц өнгө аястай болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, өрнийн сонгодог хөгжмөөс улбаатай мажор, минорын тогтолцоо уг зохиолын өрнөлд чухал үүрэг биелүүлэхгүй бөгөөд харин ХХ зууны өрнийн хөгжмийн зохиомжийн нэгэн арга болох атоналийн зарчмыг түлхүү хэрэглэсэн байдаг. Тэрхүү атоналийг үндэсний таванэгшигт хөг дээр ашиглаж, шинэ дуугаралтыг бий болгож чадсан байгаа нь хөгжмийн зохиолч Б.Шаравын амжилт мөн. Атоналийн жишээ болох хэсгүүдээс:



Зураг 13. Ноотны жишээ: Гуравдугаар хэсэг



Зураг 14. Ноотны жишээ: Тавдугаар хэсэг

Нэгэнт тодорхой дэвсгэр хөг үгүй нөхцөлд аккордын дуурьслууд нь дараах байдлаар харагдах юм.



Зураг 15. Ноотны жишээ

Энэ нь ц4 + ис4 + ц4 гэсэн дараалал бүхий аккорд байдаг. Ийм аккордыг тухайн зохиолын гуравдугаар хэсэгт буюу найрал дуучдын “хууртдаг шүү дээ” хэмээн дуулдаг хэсэг дээр авч хэрэглэсэн байдаг.



Зураг 16. Ноотны жишээ: цифр 12 / 122 такт

Эдгээр аккордын бүтцийг задалж үзвэл:

Ц4 + ис4 + ц4 + ис4 + ц4 + ис4 + ц4 буюу g+c+fis+h+f+b+e+a

Хөгжмийн зохиолч Б.Шарав нь “Замбуу тивийн наран” магтуу зохиолынхоо

явцад дийлэнхдээ диссонанс дуурьслыг өргөнөөр ашигласан байдаг бол харин зохиолынхоо төгсгөлд өрнө дахины үндсэн хоёр хөгийн нэг болох мажорыг нэмэлт хоёрдугаар өрөгтэйгөөр авсан нь нарны тухай магтаал дууныхаа төгсгөлийг өргөж өгсөн, бүтээлээ гэрэл гэгээтэйгээр төгсгөж өгсөн санаачилга болж чадсан байх юм⁷.

Дүгнэлт

М.П.Мусоргскийн нэрэмжит Уралын консерваторийн оюутан Б.Шаравын “Замбуу тивийн наран” магтуу хэдийгээр “оюутны бүтээл” байх боловч хөгжмийн зохиолчийн том хэмжээний бүтээлийн хувьд, хөгжмийн төрөл зүйл болон хөгжмийн хэллэгийн хувьд ирээдүйн хөгжмийн зохиолчийн уран бүтээлийн чиг хандлагыг тодорхойлсон зохиол болж чадсан ажээ. Энэ магтуу бол ирээдүйн нэгдүгээр симфони, алдарт хоёрдугаар симфони, Б.Шаравын том хэлбэрийн бүтээлүүдийн гарц болсон байна. Үүнийг нь уг магтууны хэлбэр бүтэц, ая, аялгуу, дуурьсал, найрал хөгжмийн бичвэрүүд баталж байгаа юм.

Хөгжмийн зохиолч нь өөрөө дотоод сэтгэлийн мэдрэмжийн талаасаа тодорхой хэм, хэмнэлд үл захирагдаж, дуурьсал сэтгэлгээний элдэв “харш” дуурьслаас зайлсхийгээгүй байдаг. Дуурьсал буюу зохирлын өргөн боломжийг нээн гаргаж өгсөн байгаа нь уг зохиолын нэгэн өвөрмөц шинж юм. Тэрээр орчин үеийн хөгжмийн зохиомжийн алеаторик, сонорус болон бусад боломжит бүхий л хувилбарыг энэхүү бүтээлдээ оруулан хэрэглэсэн байгаа нь дээрх судалгаанаас ажиглагдаж байна.

“Замбуу тивийн наран” магтуу хэмээх дуулаачийн том хэлбэрийн энэхүү бүтээл бол хөгжмийн зохиолч Б.Шаравын гэх хөгжмийн ертөнц, түүний тод томруун илэрхийлэл мөн бөгөөд “...цэвэр монгол аялгууг дэлхийн хэмжээнд дуурьсгасан бүтээл” (Төрбат, 2013, 27) болсон юм.

Ашигласан материалын жагсаалт

1. Амарсайхан, А. 2022. *Бямбасүрэнгийн Шарав*. Улаанбаатар, Монгол улс.
2. Бадраа, Ж. 1956. “Манай анхны симфони.” *Цог сэтгүүл*. №4
3. Бадраа, Ж. 2017. *Их дуучны яриа. Боть II*. Улаанбаатар, Монгол улс.
4. Жанцанноров, Н. 2019. *Миний л харгуй*. Улаанбаатар, Монгол улс.
5. Жанцанноров, Н. 2009. *Монголын хөгжмийн 12 хөрөг*. Улаанбаатар, Монгол улс.
6. Жанцанноров, Н. 2009. *Монгол хөгжмийн эгшиг-сэтгэлгээний онолын утга тайлал*. Улаанбаатар, Монгол улс.
7. Котляровский И. 1983. *Музыкально-теоретические системы европейского искусства*. Киев.

⁷ Өрнийн хөгжмийн соёлд байх бароккогийн хөгжмийн бүтээлүүд ихэвчлэн мажорын өнгө аястай төгсдөг байсан нь мөн л өдрөг үзэл санааг илэрхийлсэн болж таардаг.

8. 2019, *Монголын хөгжсдийн зохиолчид*. Улаанбаатар.
9. Смирнов Б.Ф. 1975. *Музыка нарооной Монголии*.
10. Цэдэв, Д. 2005. *Шүлэг аялгууны шүтэлцээ*. Улаанбаатар, Монгол улс.
11. Энхбулаг, С., Баттогоо, Ш., Дэлгэрсайхан, Ц. 2021. *Монголын хөгжсдийн түүх-XX зуун*. Улаанбаатар, Монгол улс.
12. Энэбиш, Ж. 2007. *Аман уламжлалт болон бичгийн хөгжсдийн харилцан шүтэлцээ*. Улаанбаатар, Монгол улс.
13. Энэбиш, Ж. 2017. *Монгол хөгжсдийн их нүүдэл. I-V боть*. Улаанбаатар, Монгол улс.
14. Энэбиш, Ж. 2007. *Уран сайхны шүүмж буюу онгодыг өдөөгч халгай*. Улаанбаатар, Монгол улс.
15. Төрбат, Д. 2013. “Уяхан замбуу тивийн уянга.” *Б.Шарав – амьдрал, уран бүтээлийнхээ тухай сонин, сэтгүүл, радио, телевизэд өгсөн ярилцлагын эмхэтгэл*.